

СҮҮЛИЙН 27.09.2021

**БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

## ҮНДСЭН АГУУЛГА

<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ</b>		<b>Хуудасны дугаар</b>
Зүйл 1	Техникийн зохицуулалтын зорилго	
Зүйл 2	Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах тухай техникийн зохицуулалтын үндсэн ойлголтууд	
Зүйл 3	Техникийн зохицуулалтын хамрах хүрээ	
Зүйл 4	Техникийн зохицуулалтын нэр томъёо, тодорхойлолт	
Зүйл 5	Барилгын материалын түүхий эд, бүтээц, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зарчим	
Зүйл 6	Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний, эрчим хүчний алдагдлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд тавих ерөнхий шаардлага	
Зүйл 7	Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлын шаардлага	
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ: БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭЦ БА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, НИЙЛҮҮЛЭЛТ (ИМПОРТ,ЭКСПОРТ ) ЭРХЛЭХ</b>		
Зүйл 8	Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр	
Зүйл 9	Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр	
Зүйл 10	Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг буцааж татах	
Зүйл 11	Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох бүртгэл	
Зүйл 12	Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн үүрэг	
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ: БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭЦ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨНД ТАВИХ ШААРДЛАГА</b>		
Зүйл 13	Барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, химийн бодис, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүний хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх ерөнхий шаардлага	
Зүйл 14	Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний эрчим хүчний үр ашгийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага	
Зүйл 15	Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүйн шаардлага	
Зүйл 16	Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний сав баглаа, боодолд тавих шаардлага	
Зүйл 17	Импортын болон экспортын барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнд тавих шаардлага	

Зүйл 18	Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний хаягжуулалт ба хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулахаас урьдчилан сэргийлэх шаардлага	
Зүйл 19	Барилгын материал, бүтээц , бүтээгдэхүүнд хийгдэх чанарын хяналт	
Зүйл 20	Барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын үнэлгээ	
Зүйл 21	Барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын баталгаа	
Зүйл 22	Барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалт	
Зүйл 23	Импортын барилгын материал, бүтээгдэхүүний чанар , аюулгүй байдал	
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ТӨРИЙН ҮҮРЭГ, ХЯНАЛТ</b>		
Зүйл 24	Техникийн зохицуулалтын хэрэгжилтэд тавих төрийн хяналт	
Зүйл 25	Барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, материал, бүтээц , бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаарх төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг	
<b>ТАВДУГААР БҮЛЭГ: ХАРИУЦЛАГА, ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА</b>		
Зүйл 26	Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага	
Зүйл 27	Шилжилтийн журам	
Зүйл 28	Техникийн зохицуулалтын үйлчлэх хугацаа	
Хавсралт-1	Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын гол шаардлагууд	
Хавсралт-2	Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт	
Хавсралт-3	Барилгын материал, хийц, бүтээгдэхүүний техникийн зохицуулалтын хяналтын хуудас	

## БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

2021 оны .... сарын ..... өдөр

Улаанбаатар хот

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл. Техникийн зохицуулалтын зорилго

1.1 Энэхүү техникийн зохицуулалтын зорилго нь барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээний бүх үе шатанд барилгын материалын эрдэс ба органик түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.1.1 Үндсэн хуулиар олгогдсон ард иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрх, эрүүл мэндийг хамгаалах;

1.1.2 Хуулийн этгээд, хувь хүн болон төр, орон нутгийн өмчийг хамгаалах;

1.1.3 Хүрээлэн буй орчны унаган төрх, ургамал, амьтны амьдрал, аюулгүй байдлыг хамгаалах;

1.1.4 Байгаль орчин, хүн ам, ан амьтны аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийн үйлчлэлээс урьдчилан сэргийлэх;

1.1.5 Галын аюулаас урьдчилан сэргийлэх;

1.1.6 Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх.

#### 2 дугаар зүйл. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн зохицуулалтын үндсэн ойлголтууд

2.1 Барилгын материал, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн зохицуулалт нь Монгол улсын “Үндсэн хууль”, “Үндэсний аюулгүй байдлын тухай”, “Барилгын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Усны тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Галын аюулгүй байдлын тухай”, “Цөмийн энергийн тухай”, “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай”, “Төрийн хяналт, шалгалтын тухай” хуулиуд болон эдгээртэй холбогдож гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрднэ.

#### 3 дугаар зүйл. Техникийн зохицуулалтын хамрах хүрээ

3.1. Энэхүү техникийн зохицуулалт нь барилгын материалын эрдэс ба органик түүхий эдийн олборлолт, боловсруулалт, барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон тэдгээрийг хадгалах, тээвэрлэх, худалдах, импортлох, экспортлох, савлах, хаяглах зэрэг сүлжээний бүх үе шатанд хамаарна.

3.2. Энэхүү техникийн зохицуулалтыг Монгол Улсын нутаг дэвсгэрт барилгын материалын зориулалтаар олборлолт, боловсруулалт, үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа эрхлэгч иргэн, хуулийн этгээд мөрдөнө.

3.3. Энэхүү техникийн зохицуулалт нь барилга, байгууламж, амьний сууцанд өмнө нь ашиглагдаж байгаад давтан ашиглагдах барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнд хамаарахгүй.

3.4. Энэхүү техникийн зохицуулалт нь иргэн зөвхөн өөрийн хувийн хэрэгцээндээ зориулан барилгын материал үйлдвэрлэх, импортлох, харилцаанд хамаарахгүй.

3.5. Энэхүү техникийн зохицуулалтаар барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүнд заавал тавигдах шаардлагуудыг тогтооно:

3.5.1. Барилга, байгууламжийн угсралтын үеийн аюулгүй байдлын шаардлага;

3.5.2. Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүн, тэдгээрийн үйлдвэрлэлийн үйл явц, хадгалалт ба тээвэрлэлтийн аюулгүй байдалын шаардлагууд;

3.5.3. Сав баглаа боодол ба шошгожуулалтад тавигдах шаардлага;

3.5.4. Химийн хортой, шатамхай, галд тэсвэргүй түүхий эд, материал,, бүтээцүүдэд тавих шаардлагууд;

3.5.5. Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх шаардлагууд зэрэг болно.

3.6. Энэ техникийн зохицуулалтаар барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний тохирлын үнэлгээг тогтооно.

#### 4 дүгээр зүйл. Техникийн зохицуулалтын нэр томъёо, тодорхойлолт

4.1. Энэ техникийн зохицуулалтад хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. **“барилгын материал”**<sup>1</sup> гэж байгалийн эрдэс түүхий эд, болон органик гаралтай бүтээгдэхүүн буюу үйлдвэрийн нөхцөлд зохиомлоор гаргаж авсан стандарт, эрүүл ахуй, экологийн шаардлагыг хангасан барилга байгууламжид хэрэглэх материал, бүтээц, бүтээгдэхүүнийг барилга угсралт, өргөтгөл шинэчлэлт, их засварт үндсэн болон туслах материал болж хэрэглэх барилга байгууламжийн хамгаалалтын буюу өнгөлгөө, заслын ажилд ашиглах төрөл бүрийн бүтээц, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн нөхцөлд бэлтгэсэн, үйлдвэрлэсэн, импортолсон бүтээгдэхүүн буюу барилгын ажлыг бүрэлдүүлэхийн тулд хэрэглэх материалыг;

4.1.2. **“барилгын бүтээгдэхүүн”**<sup>2</sup> гэж эрдэс түүхий эд, барилгын материал ашиглан үйлдвэрлэлийн нөхцөлд бүтээсэн, барилга байгууламжид хэрэглэхээр зориулан үйлдвэрлэсэн зүйлийг;

4.1.3. **“барилгын бүтээц”**<sup>3</sup> гэж барилгын материал, бүтээгдэхүүнийг ашиглан үйлдвэрлэлийн технологиор бэлтгэсэн тодорхой даацын болон тусгаарлах хашлага, эсвэл гоо зүйн чиг үүрэг бүхий хоорондоо холбогдсон элемент хэсгүүдээс тогтох барилга байгууламжийн бүрдэл хэсгийг;

4.1.4. **“барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний аюулгүй байдал”**<sup>4</sup> гэж барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг зориулалтын дагуу бэлтгэж хэрэглэхэд хүний эрүүл мэнд, амь нас, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулахгүй, сөргөөр нөлөөлөхгүй байхаас гадна гэнэтийн ослын үзэгдлийг оруулаад аливаа үйлчилгээг эсэргүүцэх чадавхийг;

4.1.5. **“барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний эрүүл ахуй”** гэж барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, борлуулалтын сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн нөхцлийг хангахад шаардагдах бүхий л нөхцөл, шаардлагыг;

4.1.6. **“барилгын материал, бүтээц бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, борлуулалтын сүлжээ”** гэж барилгын материалыг боловсруулах, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг тусламжаар авах, өгөх үйл ажиллагааг;

4.1.7. **“үйлдвэрлэл эрхлэх”** гэж эрдсийн болон органик гаралтай түүхий эдийг олборлох, боловсруулах, тэдгээрийг зах зээлд нийлүүлэхийг;

4.1.8. **“барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, борлуулалтын сүлжээнд ашиглах хэрэгсэл”** гэж машин техник, тоног төхөөрөмж, агуулах, багаж хэрэгсэл, сав, баглаа боодол, тавиур,

улавч, чингэлэг зэрэг барилгын материал, түүхий эд, бүтээц, бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдан борлуулахад ашиглаж, хэрэглэж байгаа зүйлийг;

4.1.9. **“хадгалах хугацаа”** гэж заасан хугацаанд зохих нөхцөлийн дагуу хадгалж, хэрэглэхэд тухайн барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний чанар хэвийн стандартын түвшинд байх, тухайн хугацаа хэтрэхэд бүтээгдэхүүний аюулгүй байдал нь алдагдахгүй боловч чанарын үзүүлэлт нь муудах буюу өөрчлөгдөх хүртлэх хугацааг;

4.1.10. **“хэрэглэж дуусах хугацаа”** гэж заасан хугацаанд тухайн барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний аюулгүй байх, тогтоосон хугацаа өнгөрөхөд бүтээгдэхүүний аюулгүй байдал нь алдагдах хугацааг;

4.1.11. **“гологдол бүтээгдэхүүн”** гэж барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний орц найрлагад зайлшгүй орох зүйлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хийгээгүй, хассан, эсхүл өөр зүйлээр орлуулсан, хөлдөөх, халаах, норгох, бохирдох зэргээр буруу хадгалаж чанараа алдсан бүтээгдэхүүний өнгө үзэмжийг засах, жин хэмжээг нэмэх, хасах зэргээр бодит байдлыг нь нуун далдалсан, өөрчилсөн материал, бүтээц, бүтээгдэхүүнийг;

4.1.12. **“барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч”<sup>5</sup>** гэж барилгын ажилд хэрэглэх материал, бүтээц, бүтээгдэхүүн, бүтээц үйлдвэрлэгч хуулийн этгээд, хувь хүнийг;

4.1.13. **“барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт”** гэж барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүн дэх хүний эрүүл мэнд, байгаль орчмнд нөлөөлөх сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх доод хэмжээг;

4.1.14. **“үйлдвэрлэлийн зохистой дадал”** гэж үйлдвэрлэлийн бүх үе шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад шаардагдах нөхцөл, хяналт, үйл ажиллагааг;

4.1.15. **“тохирлын гэрчилгээ”** гэж бүтээгдэхүүн нь тогтоосон шаардлагад нийцсэнийг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.16. **“нийлүүлэгчийн мэдэгдэл”** гэж бүтээгдэхүүн нь тогтоосон шаардлагад нийцэж байгаа талаар үйлдвэрлэгч, эсхүл нийлүүлэгчээс бичгээр гаргасан нотолгоог;

4.1.17. **“стандартчилал”** гэж бүтээгдэхүүн, үйлчилгээний харилцан орлуулалт, мэдээлэл, техник, хэмжилт, сорилтын нэгдмэл, нийцтэй, аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтээр, дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагааг;

4.1.18. **“стандарт”** гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг;

4.1.19. **“техникийн зохицуулалт”** гэж бүтээгдэхүүний тодорхойлолт, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, стандарт, техникийн үзүүлэлт болон шаардлагыг эрх бүхий байгууллагаас баталсан заавал дагаж мөрдөх баримт бичгийг;

4.1.20. **“тохирлын үнэлгээ”** гэж бүтээгдэхүүн, ажилтны ур чадвар, менежментийн тогтолцоо нь стандарт техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагааг;

4.1.21 **“тохирлын баталгаа”** гэж бүтээгдэхүүн нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцэж байгааг тодорхойлсон баримт бичгийг;

<sup>1</sup>MNS ISO 670715-2010 Барилга ба иргэний барилга байгууламжийн тайлбар толь I хэсэг ерөнхий нэр томьёо 6.1.2

<sup>2</sup>MNS ISO 670715-2010 Барилга ба иргэний барилга байгууламжийн тайлбар толь I хэсэг ерөнхий нэр томьёо 6.1.1

<sup>3</sup>MNS ISO 670715-2010 Барилга ба иргэний барилга байгууламжийн тайлбар толь I хэсэг ерөнхий нэр томьёо 5.1.2

<sup>4,5</sup>MNS ISO 670715-2010 Барилга ба иргэний барилга байгууламжийн тайлбар толь I хэсэг ерөнхий нэр томьёо 9.3.82

4.1.22 “**үйлчлүүлэгч**”-бүтээгдэхүүний стандарт техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэнийг баталгаажуулалтын байгууллагын өмнө хариуцах хуулийн этгээд, хувь хүнийг;

4.1.23 “**үйл явц**” –оролтыг гаралт болгон хувиргах харилцан уялдаа буюу харилцан үйлчлэл бүхий багц үйл ажиллагааг;

4.1.24 “**үйлчилгээ**”-нийлүүлэгч ба хэрэглэгчийн холбоосоор зайлшгүй гүйцэтгэсэн наад зах нь нэг үйл ажиллагааны үр дүн бөгөөд ихэвчлэн биет бус зүйлийг;

4.1.25 “**бүтээгдэхүүний шаардлага**”-баталгаажуулалтын схемийн дагуу тодорхойлсон стандарт буюу бусад норматив баримт бичигт заасан, бүтээгдэхүүнд шууд хамаарах шаардлагыг;

4.1.26 “**баталгаажуулалтын схем**”- нэг ижил тогтоосон шаардлага, дүрэм болон журам хэрэглэх тухайн бүтээгдэхүүнд хамааралыг;

4.1.27 “**тохирлын үнэлгээний байгууллага**”-тохирлын үнэлгээний үйлчилгээ үзүүлдэг байгууллагыг;

4.1.28 “**итгэмжлэлийн байгууллага**”- итгэмжлэлийг явуулах эрх бүхий байгууллагыг;

4.1.29 “**тохирлын үнэлгээний тогтолцоо**”-тохирлын үнэлгээг гүйцэтгэх дүрэм журамыг;

4.1.30 “**тохирлын үнэлгээний схем**”-тохирлын үнэлгээний тогтоосон об'ектод хамаарах тогтоосон нэгэн адил шаардлага, онцлог дүрэм, журам хэрэглэх тохирлын үнэлгээний тогтолцоог;

4.1.31 “**оролцогч**”-тогтолцоо буюу схемд оролцогч тогтолцоо буюу схемийн удирдлагад оролцох боломж эдлэхгүйгээр тогтолцооны дүрмийн дагуу ажиллаж буй байгууллагыг;

4.1.32 “**дээж авалт**”-тохирлын үнэлгээний об'ектоос зохих журмын дагуу дээж авахыг;

4.1.33 “**сорилт**” –тохирлын үнэлгээний об'ектын нэг эсхүл хэд хэдэн үзүүлэлтийн тодорхойлохыг;

4.1.34 “**хяналт**”-бүтээгдэхүүний зохион бүтээлт, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл явцыг шалгаж тэдгээрт тавих тодорхой шаардлагад нийцсэнийг эсхүл мэргэжлийн дүгнэлтэд үндэслэн ерөнхий шаардлага хангасаныг нь тодорхойлохыг;

4.1.35 “**дүн шинжилгээ**”-сонгох болон тодорхойлох үйл ажиллагаа, тэдгээрийн үр дүнг тохирлын үнэлгээний об'ект тогтоосон шаардлагыг биелүүлж байгаатай холбогдсон тохиромжтой, хангалттай бөгөөд үр нөлөөтэй байдлыг магадлахыг;

4.1.36 “**баталгааны хамрах хүрээ**”-баталгаанд хамрагдах тохирлын үнэлгээний об'ектын цар хүрээ буюу үзүүлэлтүүдийг;

4.1.37 “**баталгаажуулалт**”-бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн үйл явц, тогтолцоо буюу ажилтанд хамаарах хөндлөнгийн баталгааг;

4.1.38 “**итгэмжлэл**”-тохирлын үнэлгээний байгууллагын тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэжил чадвартайг нь албан ёсоор харуулсан хөндлөнгийн этгээдийн баталгааг;

4.1.39 “**магадлан хяналт**”-тохирлын баталгаажуулалтын хүчин төгөлдөр байдлыг хадгалах суурь болгож тохирлын үнэлгээний үйл ажиллагааг системтэйгээр давтан явуулахыг.

**5 дугаар зүйл. Барилгын материалын түүхий эд, бүтээц, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зарчим**

5.1. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад дараах зарчмыг баримтална:

5.1.1 Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүнийг зориулалт ба түүнд дагалдах баримт бичгийн дагуу хэрэглэсэн нөхцөлд ард иргэдийн амьдрал, эрүүл мэнд, хувь хүн, хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмч, хүрээлэн байгаа орчин, ургамал амьтаны хэвийн амьдралд аюул занал учруулахгүй байна;

5.1.2 Барилга, байгууламжийн ажилд хэрэглэж байгаа барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүн нь барилга, байгууламжийн ашиглалтын явцад эрчим хүчний зохистой хэрэглээг хангах ба үргүй зарцуулалтыг бууруулахаар тооцож үйлдвэрлэн байна;

5.1.3 Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүн нь тэдгээрт дагалдах баримт бичгийн шаардлагыг хангасан байна;

5.1.4 Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний батлагдсан хадгалалт, тээвэрлэлт, хэрэглээний нөхцлийг мөрдсөн тохиолдолд, хэрэглээний тогтоогдсон хугацаа (үйлдвэрлэгчээс хугацаа тогтоосон бол)-ны дотор өөрийн хэрэглээний шинж чанар, үзүүлэлтээ хадгалсан байна;

5.1.5 Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүн нь тэдгээрийн үйлдвэрлэл, импорт, экспорт, нийлүүлэлт, борлуулалтын сүлжээний бүх шат, хадгалалт, тээвэрлэлт ба хэрэглэх нөхцөлд аюулгүйн шаардлагыг хангасан байна;

5.1.6. Барилга, байгууламжийг угсрах үед барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүнийг зураг төсөл, дагалдах баримт бичигт тодорхойлсон зориулалтыг хатуу чанд баримтална;

5.1.7. “Барилгын тухай” хуулийн дагуу барилга, байгууламжийн ажлыг гүйцэтгэж байгаа этгээд нь тухайн орон нутагт үйлдвэрлэж, барилгад хэрэглэж байгаа барилгын материал, бүтээгдэхүүн нь зураг төслийн шаардлагын тохирлыг хангаж байгаа эсэхийг барилгын ажлын үргэлжилэх бүх хугацааны турш хянадаг байна;

5.1.8. Барилгын зураг төсөл, барилга байгууламжийн ашиглалтын баримт бичигт тусгасан бүтээгдэхүүн болон бүтээц хэрэглэсэн бол барилга ашиглалтын үед тэдгээрийн эдэлгээний хугацаатай холбоо бүхий шошгололт болон дагалдах баримт бичигт заасан бусад үзүүлэлтүүдийг байнгын хяналтад авна. Ашиглалтын баримт бичигт тусгагдаагүй бүтээгдэхүүн болон бүтээц хэрэглэх тохиолдолд зураг төсөл зохиогчтой зөвшилцсөн байна;

5.1.9. Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүнийг хэрэглэх үед холбогдох хууль тогтоомжуудаар тогтоосон барилга, байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангахаас гадна, зураг төсөл боловсруулахдаа үндсэн өгөгдөл болох стандарт, норматив техникийн баримт бичгийн жагсаалтад орсон барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний үүрэг ба хэрэглээний тохирол, аюулгүйн шаардлагын үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ;

5.1.10. Стандартчиллын баримт бичгүүдийг зураг төсөлд хэрэглэх нь техникийн зохицуулалтад (Хавсралт-1) тусгагдсан барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний аюулгүй байдлын бүх шаардлагуудыг мөрдөх хангалттай нөхцөл болно;

5.1.11. Стандартчиллын баримт бичгийг хэрэглэхгүй байх нь техникийн зохицуулалтын шаардлагыг мөрдөхгүй гэсэн ойлголт биш бөгөөд энэ тохиолдолд уг техникийн зохицуулалтын шаардлагаар барилгын материал, бүтээц,



бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалтыг үндэсний болон гадаадын үйлдвэрлэгчээс нийлүүлж буй бүтээгдэхүүний тохирлыг хангаагүй асуудлыг байгуулсан гэрээний хариуцлагаар зохицуулна;

5.1.12. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, импорт эрхлэгч нь үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний өөрт хамаарах үе шатанд барилгын материалын түүхий эд, бүтээц, бүтээгдэхүүнийхээ аюулгүй байдлыг хариуцана;

5.1.13. Барилгын материалын түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаа, баримтад тулгуурлан тодорхойлно;

5.1.14. Хяналт шалгалт нь эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байна.

## **6 дугаар зүйл. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний, эрчим хүчний алдагдлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд тавих ерөнхий шаардлага**

6.1. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг, зориулалт түүнд дагалдах баримт бичгийн дагуу хэрэглэсэн нөхцөлд иргэдийн амьдрал, эрүүл мэнд, хувь хүн, хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмч, хүрээлэн буй орчин, ургамал амьтны амьдрах хэвийн нөхцөлд аюул занал учруулахгүй байна.

6.2. Барилга, байгууламжийн ажилд хэрэглэж байгаа барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүн нь барилга, байгууламжийн ашиглалтын явцад эрчим хүчний зохистой хэрэглээг ханган, үргүй зарцуулалтыг бууруулахаар бүтээгдсэн байна.

6.3. Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүнийг хэрэглэх үед “Барилгын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Галын аюулгүй байдлын тухай”, “Цөмийн энергийн тухай”, “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулиудаар тогтоосон зохих шаардлагуудыг мөрдөх нөхцлийг хангана.

## **7 дугаар зүйл. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүйн шаардлага**

7.1 Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх явцад дараах нөхцөл хангагдсан байвал зохино:

7.1.1 Үндсэн түүхий эд ба материалын аюулгүй байдлын шаардлагад үйлдвэрлэгч ба хөндлөнгийн хяналт гүйцэтгэх эрх бүхий байгууллага хяналт тавина;

7.1.2 Үйлдвэрлэж байгаа барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд сөрөгөөр нөлөөлж буй үйлдвэрлэлийн үйл явцын үйлдлүүдийг үйлдвэрлэгч тусгайлан тогтоож, онцгой хариуцлагатай үйлдлүүдийг үйлдвэрлэгчийн зүгээс байнгын хяналтанд авч, лабораторийн шинжилгээнд хамруулж байвал зохино. Хяналт шинжилгээний дүнг баримтжуулан, нэгээс доошгүй жил хадгална;

7.1.3 Бүтээгдэхүүнийг хүлээн авсантай холбоотой хяналтын материалыг баримтжуулан гурваас доошгүй жил хадгална. Баримтжуулалт ба хадгалалтыг үйлдвэрлэгч (цаасан буюу цахим) хэлбэрээр хийж түүний хадгалалтын бүх хугацааны турш үнэн зөвийн болон үл өөрчлөгдөх баталгааг хангасан байна;

7.1.4 Барилгын материал, бүтээгдэхүүний сорьцыг үйлдвэрлэгч, хэрэглэгчдэд хадгалагдах дагалдах баримт бичигт заасан нөхцлийн дагуу хэрэглээний шинж чанарыг бууруулахгүйгээр хадгалбал зохино.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ**  
**БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭЦ БА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ,**  
**НИЙЛҮҮЛЭЛТ (ИМПОРТ, ЭКСПОРТ ) ЭРХЛЭХ**

**8 дугаар зүйл. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн талаарх мэдээлэл**

8.1. Барилгын материал, бүтээц бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь дараах мэдээллийг маягтын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр нутаг дэвсгэр дэх барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд мэдээлнэ:

8.1.1.Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн нэр, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистрийн дугаар, байршил, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг;

8.1.2.Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр, дотоод хяналтын журам.

8.2. Энэхүү техникийн зохицуулалтын 8.1-д заасан маягтыг тухайн бүтээгдэхүүний стандартад тусгасан заалтын дагуу мэдээлнэ;

8.3. Эрх бүхий мэргэжлийн байгууллага үйлдвэрлэл, нийлүүлэлтийг шинээр эрхлэгчийн үйл ажиллагаанд энэхүү техникийн зохицуулалтын 8.1-д заасан мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор “Барилгын тухай” хууль болон техникийн зохицуулалтад заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд урьдчилсан хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргана.

8.4. Эрх бүхий мэргэжлийн байгууллага энэхүү техникийн зохицуулалтын 8.1-д заасан мэдээлэлд тулгуурлан эрсдлээс хамгаалсан хяналт шалгалтыг төлөвлөнө:

8.4.1.Барилгын материалын түүхий эд олборлох, боловсруулах, үйлдвэрлэл;

8.4.2. Барилгын бүтээц, бүтээглэхүүний нийлүүлэлт .

8.5. “Барилгын тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 -д зааснаас бусад тохиолдолд барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч энэхүү техникийн зохицуулалтын 8.3-д заасны дагуу мэдээлснээр үйл ажиллагаагаа эхлүүлж болно.

8.6. Эрх бүхий мэргэжлийн байгууллага энэхүү техникийн зохицуулалтын 8.3-д заасан хугацаанд дүгнэлт гаргаагүй тохиолдолд барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь үйлдвэрлэл, нийлүүлэлтээ эхлүүлэх эрхтэй.

8.7. Барилгын шинэ нэр төрлийн материал, бүтээц, бүтээгдэхүүний аюулгүйн байдлын үзүүлэлт, түүнийг боловсруулах, үйлдвэрлэх, нийлүүлэх нөхцөл, шаардлагыг тусгасан байна;

8.8. Барилгын материал, бүтээц бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч энэхүү техникийн зохицуулалт 8.1-д заасан мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд энэ тухайгаа 15 хоногийн дотор хэрэглэгчдэд мэдэгдэнэ;

**9 дүгээр зүйл. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр**

9.1. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны төрлөөс хамааран дараах зохистой дадлыг нэвтрүүлнэ:

9.1.1.Барилгын материалын эрдсийн болон органик гаралтай түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүний анхан шатны олборлолт, боловсруулалтын зохистой дадал;

9.1.2. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээний бүх үе шатан дахь эрүүл ахуйн зохистой дадал;

9.2. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт эрхлэгч нь үйл ажиллагаандаа түүхий эд, материал, бүтээц, эдлэхүүний аюулгүй байдалд нөлөөлөх аюулыг илрүүлэн тогтоох, үнэлэн дүгнэх, хянан шалгах зорилгоор аюулын дүн шинжилгээ хийж, эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог хэрэгжүүлж болно;

## **10 дугаар зүйл. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг буцааж татах**

10.1. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт эрхлэгч түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүнээ хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзвэл тэдгээрийг борлуулалтын сүлжээнээс буцааж татна.

10.2. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт эрхлэгч дараах тохиолдолд хяналтын байгууллагын шийдвэрээр түүхий эд, материал, бүтээц, эдлэхүүнээ борлуулалтын сүлжээнээс буцааж татна:

10.2.1. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнээс шалтгаалсан хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх илрэл гарсан;

10.2.2. Тухайн түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүн эрүүл ахуйн шаардлага болон аюулгүй байдлын үзүүлэлтийг хангаагүй, буруу хаягласан, чанаргүй бүтээгдэхүүн болохыг нь хяналт шалгалтаар тогтоосон;

10.2.3. Тухайн импортолсон, экспортолсон барилгын материал, түүхий эд, бүтээц, бүтээгдэхүүний аюултай байдлын талаарх сэрэмжлүүлэг олон улсын мэдээллийн сүлжээгээр мэдээлэгдсэн.

10.3. Энэхүү техникийн зохицуулалтын 10.1, 10.2-т заасан үндэслэлээр барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг буцааж татсан тохиолдолд барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт эрхлэгч нь энэ тухайгаа холбогдох хяналтын байгууллага, хэрэглэгчид болон тухайн түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авсан дараагийн шатны үйл ажиллагаа эрхлэгчид нэн даруй мэдэгдэнэ.

10.4. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт эрхлэгч барилгын материал, бүтээц, эдлэхүүнийг буцааж татсан, тэдгээртэй холбогдсон арга хэмжээний талаарх мэдээлэл, баримт бичгийг хадгална.

10.5. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт эрхлэгч энэхүү техникийн зохицуулалтын 10.2-т заасны дагуу бүтээгдэхүүнээ буцааж татсан тохиолдолд хяналтын байгууллагын шийдвэрийг гартал буцааж татсан он, сар, өдрийг тэмдэглэн тухайн барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг тусгаарлан битүүмжилж хадгална.

10.6. Хүний амь нас, эрүүл мэндэд аюултай, гарал үүсэл нь тодорхойгүй барилгын материал, түүхий эд, бүтээц, бүтээгдэхүүнийг хэрхэх асуудлыг “Хог хаягдлын тухай” хуулийг хэрэгжүүлэх талаар гарсан “Татах, устгах, дахин боловсруулах тухай” журмаар зохицуулна.

10.7 Энэхүү техникийн зохицуулалтын 10.2, 10.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлсэнтэй холбогдон гарсан зардал, лабораторийн шинжилгээний төлбөр, бусдад учирсан хохирлыг буруутай нь тогтоогдсон барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт эрхлэгч хариуцна.

10.8. Хяналтын байгууллага энэхүү техникийн зохицуулалтын 10.2-т заасны дагуу буцааж татсан барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний талаар мэдээллийн сан бүрдүүлж, нийтэд мэдээлнэ.

## **11 дүгээр зүйл. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох бүртгэл**

11.1. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох бүртгэлийг үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний өөрт хамаарах үе шатанд хөтөлнө.

11.2. Энэхүү техникийн зохицуулалтын 11.1-д заасан бүртгэлийг ашиглан барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, борлуулалтын сүлжээн дэх эрсдэл гарсан үе шатыг тогтооно.

11.3. Энэхүү техникийн зохицуулалтын 9.2-т заасны дагуу түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтооно;

11.4. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь энэхүү техникийн зохицуулалтын 11.1-д заасан бүртгэлийг түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүний хэрэглэж дуусах хугацаа дууссанаас хойш 30-аас доошгүй хоногийн хугацаанд, эсхүл хадгалах хугацаа дууссанаас хойш нэгээс доошгүй жилийн хугацаанд тус тус хадгална.

11.5. Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох бүртгэл хөтлөх аргачлалыг холбогдох байгууллага батална.

## **12 дугаар зүйл. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн үүрэг**

12.1. Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь дараах үүргийг хүлээнэ:

12.1.1 Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээний бүх үе шатанд энэхүү техникийн зохицуулалт болон холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлж, буруутай үйл ажиллагааныхаа улмаас учирсан хохирлыг хариуцах;

12.1.2. Энэхүү техникийн зохицуулалтын 9.1 -д заасан зохистой дадлыг өөрийн үйлдвэрлэлийн бүх үе шатанд хэргэжүүлэх;

12.1.3. Энэхүү техникийн зохицуулалтын 11 дүгээр зүйлд заасан барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох бүртгэлийг хөтлөх;

12.1.4. Энэхүү техникийн зохицуулалтын 10 дугаар зүйлд заасны дагуу түүхий эд барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнээ буцааж татах;

12.1.5. Үйл ажиллагаагаа эхлүүлэхээс өмнө энэхүү техникийн зохицуулалтын 8 дугаар зүйлд заасны дагуу мэдээлэх, урьдчилсан хяналт, шалгалтад хамрагдах;

12.1.6. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох болон дотоод хяналт, шалгалтын бүртгэл, тэмдэглэл, тайлан тооцоо, лабораторийн сорилтын дүн зэрэг мэдээлэлтэй холбоотой баримт бичгийг хадгална.

12.3. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгчдэд дараах үйлдлийг хориглоно:

12.3.1. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлт, эрүүл ахуйн шаардлагыг хангаагүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй, буруу хаягласан, түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх;

12.3.2. Хяналтын байгууллага үйл ажиллагааг нь түр болон бүрмөсөн зогсоосон тохиолдолд үйл ажиллагаа явуулах.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ**  
**БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭЦ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД**  
**ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨНД ТАВИХ ШААРДЛАГА**

**13 дугаар зүйл. Барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, химийн бодис, материал, бүтээц, бүтээгдэхүүний хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх ерөнхий шаардлага**

13.1 Барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, химийн бодисууд, материал, бүтээц, бүтээгдэхүүнийг дараах тохиолдолд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэж үзнэ:

13.1.1. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх химийн бодисын агуулга зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн;

13.1.2. Зориулалтын бус сав, баглаа боодол, тээврийн хэрэгсэл, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж ашигласан;

13.1.3. Эрүүл ахуй, үйлдвэрлэлийн гоо зүйн горим зөрчиж, барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээний дараагийн үе шатанд эрсдэл гаргасан;

13.1.4. Монгол Улсад болон олон улсад бүртгэгдээгүй, эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй, хориглосон түүхий эд материал ашигласан;

13.1.5. Энэхүү техникийн зохицуулалтын 11 дүгээр зүйлд заасны дагуу бүртгэгдээгүй химийн бодис ашиглаж үйлдвэрлэсэн;

13.1.6. Цацраг идэвхит радиийн эквивалентийн үзүүлэлт MNS 5072 стандартын шаардлагад заасан дээд хэмжээнээс хэтэрсэн;

13.1.7 Хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн.

13.2 Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний боловсруулалт, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрлэгч, нийлүүлэгчид бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал болон иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлэхийн тулд Олон улсын менежментийн тогтолцооны стандартууд (ISO 9001, ISO 14001, ISO 45001 гм)-ыг хэрэгжүүлнэ.

**14 дүгээр зүйл. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний эрчим хүчний үр ашгийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага**

14.1 Барилга, байгууламжийн ажилд хэрэглэж байгаа барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүн нь барилга, байгууламжийн ашиглалтын явцад эрчим хүчний зохистой хэрэглээг хангасан байна.

14.2 Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүн нь эрчим хүчний хэрэглээтэй холбоотой дагалдах баримт бичгийн шаардлагыг хангасан байна.

14.3 Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүн нь, дагалдах баримт бичиг, зураг төсөл, холбогдох стандарт, техникийн шаарлагыг хангасан, хадгалалт, тээвэрлэлт ба хэрэглээний нөхцлийг мөрдсөн тохиолдолд хэрэглээний тогтоогдсон хугацаа (үйлдвэрлэгчээс хугацаа тогтоосон бол)-нд өөрийн хэрэглээний шинж чанар, үзүүлэлтээ хадгалсан байна.

14.4 Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүн нь тэдгээрийг үйлдвэрлэх, нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх ба хэрэглэх үеийн эрчим хүчний аюулгүйн шаардлагыг хангасан байна.

14.5 Барилга, байгууламжийг угсрах үед барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний зураг төсөл, дагалдах баримт бичигт эрчим хүчний хэрэглээний үзүүлэлтийг хатуу чанд баримтална.

## **15 дугаар зүйл. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүйн шаардлага**

15.1 Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, нийлүүлэх явцад дараах нөхцлийг хангасан байна:

15.1.1. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, нийлүүлэхдээ эрх бүхий байгууллагын тохирлын баталгаажуулалтад хамруулж, тохирлын гэрчилгээ авсан байна;

15.1.2. Аюулгүй байдлын зохих шаардлагыг мөрдөх чиглэлээр үндсэн түүхий эд олборлогч, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн дотоод хяналтаас гадна, төрийн хяналт гүйцэтгэх эрх бүхий байгууллага давхар хяналт тавина;

15.1.3 Бүтээгдэхүүнийг хүлээн авах хяналтын үр дүнг баримтжуулсан мэдээллийг гурваас доошгүй жил хадгална. Үйлдвэрлэгч, импортлогч баримтжуулсан мэдээллийг цаасан ба цахим хэлбэрээр хийж хадгалалтын бүх хугацааны турш үнэн зөвийн болон үл өөрчлөгдөх баталгааг хангасан байна.

15.1.4 Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний хадгалалт ба тээвэрлэлтийг үйлдвэрлэгч болон тэдгээрт дагалдах баримт бичигт заасан нөхцлийн дагуу барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний хэрэглээний шинж чанар хадгалагдахаар гүйцэтгэвэл зохино.

## **16 дугаар зүйл. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний сав баглаа, боодолд тавих шаардлага**

16.1 Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний сав баглаа, боодол тавиур, улавч чингэлэг нь тэдгээрийн хадгалалт, тээвэрлэлт ба борлуулалтын үед үйлдвэрлэгчийн шошгололт буюу дагалдах баримт бичигт заасан нөхцлийн дагуу хэрэглээний шинж чанарыг алдагдуулахгүй байх нөхцлийг хангасан байна.

16.2. Барилгын материалын эрдэс ба органик түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүний эрсдэлээс шалтгаалан зайлшгүй сав, баглаа боодол, шошго хэрэглэх журмыг барилгын материалын хяналт хариуцсан төрийн байгууллага болон төрийн бус мэргэжлийн холбоо батална.

16.3 Гадаад байдлаар нь шинж чанарыг тодорхойлох боломжтой барилгын материалын эрдэс ба органик түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүний шаардлагатай мэдээллийг дагалдах хуудсанд тусгана.

16.4. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний шошго дараах мэдээллийг агуулсан байна:

16.4.1. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний нэр;

16.4.2. Үйлдвэрлэгчийн нэр, хаяг;

16.4.3. Хэмжээ, тоо ширхэг, бүтээгдэхүүний цувралын дугаар;

16.4.4. Үйлдвэрлэсэн он, сар, өдөр;

16.4.5. Хадгалах хугацаа, эсхүл хэрэглэж дуусах хугацаа;

16.4.6. Хадгалах нөхцөл;

16.4.7. Орц, найрлага;

16.4.8. Хэрэглэх арга;

16.4.9. Гаж нөлөө, хориглох заалт.

16.5 Химийн бодис, органик түүхий эд, барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний шошгод Монгол Улсад болон олон улсад хэрэглэдэг тэмдэг, тэмдэглэгээг тавина.

16.6. Импортын барилгын материал, түүхий эд, бүтээц, бүтээгдэхүүний шошгод агуулагдах мэдээллийг монгол эсвэл англи, орос хэлний аль нэгээр орчуулж бичсэн байна.

16.7. Дараах тохиолдолд эрдэс ба органик түүхий эд, барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг буруу хаягласан гэж үзнэ:

16.7.1. Шошго худал мэдээлэл агуулсан;

16.7.2. Тухайн эрдэс ба органик бус түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүн өөр нэрээр бичсэн;

16.7.3. Өөр нэр төрлийн түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг ашиглан шошгыг дуурайлгаж хуурамчаар үйлдсэн;

16.7.4. Энэ техникийн зохицуулалтын 16.4-т заасан шошгод тавьсан шаардлагыг хангаагүй;

16.7.5. Монгол Улсад болон олон улсад хэрэглэдэг тэмдэг, тэмдэглэгээг шошгод тавиагүй;

16.7.6. Унших боломжгүй, ойлгомжгүй үг, өгүүлбэр, он, сар, өдөр бичсэн;

16.7.7. Цацраг идэвхит бодисын тэмдэглэгээгүй.

16.8. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний багцалсан болон жижиглэн савласан сав, баглаа боодол дээрх шошгыг тухайн барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон нийлүүлэгч хариуцна.

16.9. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний шошгод агуулагдах нэмэлт мэдээллийг олон улсын болон Монгол Улсын стандартаар зохицуулна.

## **17 дугаар зүйл. Импортын болон экспортын барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнд тавих шаардлага**

17.1. Импортын болон экспортын барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээнд ашиглах болон хэрэглэх хүрээнд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг итгэмжлэгдсэн лабораториуд хийнэ.

17.2. Импортын барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт Монгол Улсын болон олон улс, бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрсөн шаардлага хангасан байна.

17.3. Импортын барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг шошгон дээр заасан нөхцлийн дагуу хадгална.

17.4. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний аюулгүй байдалд хяналт тавих эрх бүхий улсын байцаагч нь эрдсийн болон органик гаралтай түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасны дагуу импортлох болон экспортлох барилгын материалын түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд ашиглах болон хэрэглэхтэй холбогдох хяналт шалгалт хийнэ.

17.5. Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүнийг импортлогч, экспортолгч эхний удаа импортлох, экспортлох тохиолдолд түүний нэр, төрөл, гарал үүсэл, бүс нутаг, улс, үйлдвэрлэгчийн нэрийг ачилт хийхээс 30-аас доошгүй хоногийн өмнө хяналтын байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.

17.6. Хяналтын байгууллага барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнд импорт, экспортын өмнөх эрсдэлийн үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд ачилтын өмнөх хяналт шалгалт хийнэ.

17.7. Хяналтын байгууллага гадаадын зээл, тусламжаар нийлүүлэх болон өндөр эрсдэлтэй барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнд ачилтын өмнөх хяналт шалгалтыг хийж болно.

17.8. Импортын болон экспортын ачилтын өмнөх хяналт шалгалтын журмыг барилгын болон хяналтын асуудал хариуцсан холбогдох төрийн байгууллага батална.

**18 дугаар зүйл. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний шошгожуулалт ба хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулахаас урьдчилан сэргийлэх шаардлага**

18.1 Худалдан авагчдыг төөрөдөлд оруулах элдэв үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний аюулгүй байдал зориулалт, тэдгээрийн ашиглалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт ба хэрэглээний аюулгүй байдлыг хангахтай холбоотой мэдээллийг хаяглалтын хэлбэрээр, шаардлагатай тохиолдолд энэхүү техникийн зохицуулалтын дагуу дагалдах баримт бичигт бичвэр болон зураг байдлаар тавьсан байна.

18.2 Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн бүхий л хугацааны туршид хадгалагдах, үзэгдэх байршилд тависан хялбархан унших, гаргацтай байдлаар шошголсон байна.

18.3 Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний шошгон дээр үйлдвэрлэгч дараах мэдээллийг монгол хэл дээр тавьсан байна:

18.3.1 Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний нэр;

18.3.2 Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний үндэсний болон гадаадын үйлдвэрлэгчийн нэр ба байршил;

18.3.3 Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний зориулалт ба эдэлгээний хугацааны тухай мэдээлэл, үйлдвэрлэсэн огноо ба хэрэглэх хүчинтэй хугацаа (хэрвээ тийм хугацаа үйлдвэрлэгч ба гадаадын үйлдвэрлэгч тогтоосон бол);

18.3.4. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний хэрэглээний үндсэн шинж чанарын тухай болон тэдгээрийн ашиглалтын аюулгүйн шаардлага, түүний дотор барилгын материал, бүтээц, эдлэхүүний галын болон тэсрэх аюулын тухай мэдээлэл;

18.3.5 Барилгын материал, бүтээц бүтээгдэхүүний ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдлын дүрэм ба нөхцлийн тухай мэдээлэл (мэдээллийн ийм заалт шаардлагатай тохиолдолд);

18.3.6. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнд үйлдвэрийн гологдол, гэмтэл илэрсэн тохиолдолд авах арга хэмжээ ба үйлчлэлийн тухай мэдээлэл;

18.3.7 Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний цэвэр ба бохир жин буюу эзлэхүүн (хэрвээ үйлдвэрлэгч тийм заалтыг тогтоосон бол);

18.3.8. “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн дагуу иргэдийн ахуйн хэрэгцээнд зориулан нийлүүлэх барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний тухай мэдээлэл;

18.3.9. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын тухай энэхүү техникийн зохицуулалтын шаардлагын тохирлын баталгаажуулалтын талаархи мэдээлэл.

18.4. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүн нь онцгой аюултай болохыг урьдчилан мэдээлэх тэмдгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тавих ба шаардлагатай тохиолдолд барилгын материал, бүтээгдэхүүнийг ашиглах, хэрэглэх, хадгалах, тээвэрлэх, нийлүүлэх ба дахин ашиглах үед урьдчилан сэргийлэх арга хэмжээ болгон тавина.

18.5 Урьдчилан мэдээлэх тэмдгийг барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнд тавихаас гадна тэдгээрийн сав, баглаа боодол дээр ашиглалтын хугацааны туршид хадгалах нөхцлийг хангасан байна.

18.6. Барилгын материал, бүтээц бүтээгдэхүүний энэхүү техникийн зохицуулалтын шаардлагын тохирол нь баталгаажаагүй бол энэ техникийн зохицуулалтаар тогтоосон журмаар зэх зээлд гарах тэмдгээр шошголох, барилгад нийлүүлэхийг хориглоно.

18.7. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний тохирлыг баталгаажуулсан стандарт, норматив техникийн баримт бичгийн нэрийг тусгаж өгнө. (хэрэв барилгын



материал, бүтээц, бүтээгдэхүүн нь стандарт, норматив техникийн баримт бичгийн дагуу үйлдвэрлэгдсэн бол);

18.8. Үйлдвэрлэгч болон нийлүүлэгч нь шошгыг барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүн дээр шууд тавих боломжгүй гэж үзэж байгаа бол сав баглаа боодол дээр тависнаас бусад холбогдох мэдээллийг дагалдах баримт бичигт зааж өгнө.

18.9. Хэрвээ барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг батлагдсан стандартын дагуу үйлдвэрлэсэн бол шошго нь техникийн зохицуулалтын 16.4-т заасны дагуу барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний мэдээллийг агуулсан байна.

18.10. Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний шошго болон тэдгээрийг дагалдах баримт бичигт худалдан авагчдыг төөрөгдөлд хүргэж болзошгүй мэдээллийн баримт бичиг зааж оруулахыг хориглоно.

## **19 дүгээр зүйл. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнд хийх чанарын хяналт**

19.1. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнд хийх чанарын хяналтыг дэргэдээ лаборатори бүхий үйлдвэрлэгч дотоодын хяналтыг тогтмол хийхээс гадна энэхүү техникийн зохицуулалтын холбогдох хавсралтын (Хавсралт-1) дагуу хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн магадлах хяналтад тодорхой давтамжтайгаар хамруулна.

19.2. Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүнд заавал хийх чанарын хяналтыг дэргэдээ лабораторигүй жижиг үйлдвэрлэгчид итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораторитой гэрээний үндсэн дээр тогтмол хянуулна.

19.3 Бүтээгдэхүүний чанарын хяналтыг доорх байдлаар ангилна.

а. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн явцад тавих дотоод хяналт, шалгалт;

б. Барилга угсралтын үе шатны ажлын явцад тавих хяналт, шалгалт (гүйцэтгэгчийн);

в. Хөндлөнгийн хяналт, шалгалт (бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалт);

г. Зөвлөх эрх бүхий иргэн, хуулийн этгээд болон техникийн хяналтын байгууллагын хяналт (стандарт MNS ISO 17020);

е. Зохиогчийн хяналт.

19.4 Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн дотоод хяналтыг технологийн бүх үе шатанд /түүхий эд бэлтгэх, боловсруулахаас эхлээд бэлэн бүтээгдэхүүн, барилгыг ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэл бүх дамжлага хамаарна/ холбогдох стандартын техникийн шаардлага, техникийн нөхцлийн дагуу хийхээс гадна бүрдүүлэгч материалын зарцуулалт, эрчим хүч, хөдөлмөр зарцуулалт аль болох хамгийн бага байх нөхцөлийг бүрдүүлж хяналтыг хийнэ.

## **20 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын үнэлгээ**

20.1 Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад тохирлын үнэлгээний зорилго оршино.

20.2 Монгол улсын зах зээлд худалдаалахаар үйлдвэрлэсэн хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй барилгын материал, бүтээгдэхүүнийг “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийг баримтлан тохирлын үнэлгээнд заавал хамруулна. (Хавсралт-2)

20.3 Жагсаалтад заагаагүй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, нийлүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага, хэрэглэгчийн хүсэлтээр сайн дурын үндсэн дээр тохирлын баталгаанд хамруулж болно.

## **21 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын баталгаа**

21.1 Тохирлын баталгаа нь тохирлын гэрчилгээ болон нийлүүлэгчийн мэдэгдэл хэлбэртэй байна. Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүнд энэхүү техникийн зохицуулалтын шаардлагын дагуу заавал хийх баталгаажуулалтын мэдүүлэгч нь тэдгээрийн үйлдвэрлэгчид буюу гадаадын үйлдвэрлэгчдийн үүрэг гүйцэтгэгч этгээдүүд байж болно.

21.2 Үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь нийлүүлэгчийн мэдэгдэл гаргаж болно. Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний энэхүү техникийн зохицуулалтын шаардлагын дагуу тохирлын тухай мэдээлэгчийн мэдэгдлийг хүлээн авах; Нийлүүлэгчийн мэдэгдэл нь тохирлын гэрчилгээний нэгэн адил хүчин төгөлдөр байна.

21.3 Барилгын материал, бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийг баримтлан тохирлын гэрчилгээг олгоно.

21.4 Тохирлын гэрчилгээ нь Монгол улсад болон Монгол улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ хэлэлцээрээр тохирсон улс орнуудад хүчин төгөлдөр байна.

21.5 “Аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүн”-ийг тохирлын баталгаанд давтан хамруулахгүй.

21.6 Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн салбарын төрийн захиргааны байгууллага нь Аюулгүйн тэмдэг олгох тохирлын үнэлгээний ажлыг хариуцан гүйцэтгэх итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

## **22 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалт**

22.1 Барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалтыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2018 оны А/254 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтад заасан “Монгол улсад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах нийтлэг журам”-ын дагуу явуулна. Баталгаажуулалтын үйл явц нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

22.1.1 **Сонголт**-Баталгаажуулалтад хамруулах тухай хүсэлт хүлээн авах, бүртгэнэ.

22.1.2 Аж ахуйн нэгж байгууллага нь бүтээгдэхүүний баталгаажуулалтад хамруулах тухай хүсэлтийг загварын (баталгаажуулалтын байгууллагын гаргасан) дагуу гаргаж баталгаажуулалтын байгууллагад ирүүлнэ.

22.1.3 Бүтээгдэхүүний баталгаажуулалтад шаардлагатай баримт бичгийг хавсаргасан байна.

22.1.4 Баталгаажуулалтын байгууллага хүсэлтийг бүрдүүлэх баримт бичгийн хамт хүлээн авч бүртгэлжүүлнэ. Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний энэхүү техникийн зохицуулалтын шаардлагын заавал хийгдэх тохирлын баталгаажуулалт, хэлбэр, схемийн сонголтыг техникийн зохицуулалтын дагуу мэдүүлэгч гүйцэтгэнэ.

22.1.5 Чанарын баталгаажуулалтын байгууллагад бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалтад орох мэдүүлэгчийн захиалгыг хүлээн авах. Захиалгад бүтээгдэхүүний адилтгалд шаардлагатай бүтээгдэхүүний бодит шинж чанарын үзүүлэлтүүдийг зааж оруулсан байна; Ирүүлсэн баримт бичигт дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээллийг цуглуулна. Тухайн бүтээгдэхүүнд хамаарах техникийн үзүүлэлт шаардлагыг тодорхойлно.

22.2 Тодорхойлолт-Бүтээгдэхүүний тохирлыг баримт нотолгоонд тулгуурлан баримт бичгийн дүн шинжилгээ хийх, хэрэглэгчид нийлүүлж буй бүтээгдэхүүнтэй ижил загварын дээж авч сорилтыг итгэмжлэгдсэн лабораторит гүйцэтгүүлэх.

22.2.1 Хэрэглэгчид нийлүүлж буй бүтээгдэхүүнтэй ижил загварын дээжинд сорилт шинжилгээ явуулна.

22.2.2 Сорилт, туршилтын дээжийг үйлдвэрлэгчээс, зах зээлээс эсвэл аль алианаас нь авч болно.

22.2.3 Баталгаажуулалтын сорилтын дээжийг баталгаажуулалтын шинжээч авна.

22.2.4 Баталгаажуулалтын үйл ажиллагааг гүйцэтгэхдээ сорилтыг MNS ISO /IEC 17025, техникийн хяналтыг MNS ISO /IEC 17020, удирдлагын тогтолцооны менежментийн хувьд MNS ISO /IEC 17021, стандартуудын шаардлага хангасан итгэмжлэгдсэн лаборатори, байгууллагуудаар гүйцэтгүүлнэ.

22.2.5 Баталгаажуулалтын байгууллага нь сорилтын үр дүнг хүчин төгөлдөр норматив техникийн баримт бичгээр тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийнэ. Үйлдвэрлэгчийн хүсэлтээр буюу сайн дурын үндсэн дээр хийх баталгаажуулалтад хүсэлт гаргагчийн заасан норматив техникийн баримт бичгүүдээр тогтоосон шаардлагыг хангасаныг үнэлэн тогтоож болно. Энэхүү техникийн баримт бичигт Монгол улсад мөрдөж буй аюулгүй байдлын шаардлагуудыг тусгасан байх шаардлагатай.

22.2.6 Тохирлын үнэлгээний удирдамж, төлөвлөгөө боловсруулан, баталгаажуулалтын схем болон шинжээчийг сонгож, үнэлгээ явуулах шийдвэр гаргаж, хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

22.3 Дүн шинжилгээ-Үйлдвэрлэлийн үнэлгээг батлагдсан удирдамж, төлөвлөгөө, баталгаажуулалтын схемийн дагуу явуулна. Баталгаажуулалтын схемийн төрлөөс хамааруулан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үнэлгээнд менежментийн тогтолцооны баталгаажуулалтын үр дүнг харгалзан үзэж болно.

22.3.1 Үнэлгээнд “MNS ISO/IEC 17065:2013 Тохирлын үнэлгээ.- Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага”, “MNS ISO/IEC 17067:2014 “Тохирлын үнэлгээ. Бүтээгдэхүүний баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн заавар”, “MNS ISO/IEC TR 17026:2017 Тохирлын үнэлгээ. Биет бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн загвар” стандартуудын шаардлагыг үндэслэн боловсруулсан “Монгол улсад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах нийтлэг журам”-ын 3 дугаар хавсралтад заасан баталгаажуулалтын схемийн төрлүүдээс сонгон хэрэглэнэ. /хавсралт/

22.3.2 Үйлдвэрлэлийн үнэлгээгээр дараах шалгуур үзүүлэлтийг үнэлж тогтооно. Үүнд:

а/ бүтээгдэхүүн, үйлдвэрлэл нь стандарт норматив техник бичигт тогтоосон шаардлагыг бүрэн хангасныг холбогдох баримт бичигт үндэслэн харьцуулах аргаар үнэн зөв нотолж үнэлэх;

б/ зураг төсөл, зохион бүтээлт, загварын туршилтын баримтжуулалт;

в/ үйлдвэрлэгчийн чанарын удирдлагын тогтолцоо, чанарын дотоод хяналт, бүтээгдэхүүний чанар хангалт, чанарын жигд, тогтвортой байдал;

г/ бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологийн горимын хяналт;

д/ түүхий эдийн гарал үүсэл, сорилт, хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн хяналт;

е/ хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж, шалгалт тохируулгын хяналт;

ё/ сав баглаа, боодол, хаяг шошгын хяналт;

ж/ хэрэглэгч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, санал асуулга.

22.4 Шийдвэр-Баталгаажуулалтын байгууллага сорилтын үр дүн, үйлдвэрлэлийн үнэлгээ, (менежментийн тогтолцооны баталгаажуулалт), бүтээгдэхүүний тохирлын дүн шинжилгээ, шинжээчийн дүгнэлт, саналыг баталгаажуулалтын зөвлөлд танилцуулж тохирлын гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх тухай шийдвэрийг гаргуулна.

22.5 Баталгаажуулалтад үнэн зөв байдалд эргэлзээ төрөхөөргүй хүчин төгөлдөр стандарт, норматив техникийн баримт бичгийг ашиглана.

22.6 Гэрчилгээ олгох, бүртгэлжүүлэх- Гэрчилгээ нь бүртгэлийн дугаартай бол хүчин төгөлдөр байна.

22.6.1 Гэрчилгээнд баталгаажуулалт явуулахад үндэслэсэн баримт бичиг, баталгаажуулалтын сорилтын үр дүн, баталгаажуулалтын байгууллагын нэр хаяг, баталгаажуулалт олгосон шийдвэрийн огноо, дугаар, хүчинтэй хугацаа, баталгаажуулалтын хамрах хүрээ, үйлчлүүлэгчийн нэр хаяг, баталгаажуулалтын схемийн дагуу шаардсан бусад мэдээлэлийг тусгаж, хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн гарын үсэг буюу тамга тэмдгээр баталгаажсан байна.

22.6.2 Гэрчилгээний хүчинтэй хугацааг бүтээгдэхүүний зохион бүтээлт, боловсруулалт, үйлдвэрлэл, бүтээгдэхүүний чанарын тогтвортой байдал, норматив техникийн баримт бичгийн хүчинтэй хугацаа зэрэг үндсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан “Монгол улсад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах нийтлэг журам”-д зааснаар 3 хүртэл жилийн хугацаагаар олгоно.

22.7 Магадлах хяналт–Бүтээгдэхүүний үзүүлж болох болзошгүй хохирол, хохирлын зэрэг, үйлдвэрлэлийн тогтвортой байдал, дотоод хяналт, технологийн горимын хяналтын тогтолцоонд өөрчлөлт орсон, түүхий эд, бүтээгдэхүүний шаардлагын болон сорилтын арга аргачлалын норматив техникийн баримт бичигт өөрчлөлт орсон, бүтээгдэхүүний чанарт үл тохирол илэрсэн, бүтээгдэхүүний хаяглалт, дагалдах чанарын баримт бичигт тусгасан мэдээлэл хэрэглэгчийг төөрөлдүүлсэн, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа зэргийг шалгуур болгож магадлах үнэлгээний хамрах хүрээг тогтоож жил бүр давтамжтайгаар явуулна.

Баталгаажуулалтанд нөлөөлөх өөрчлөлт:

Үйлдвэрлэгч, хүсэлт гаргагч, нийлүүлэгчийн мэдэгдэл гаргагч аж ахуйн нэгж байгууллага, иргэн нь тохирлын үнэлгээний талаар дараах эрхтэй:

- бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх чиглэлээр дэвшилтэт стандарт, менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, тохирлын үнэлгээнд хамрагдах;
- стандарт боловсруулахад оролцох;
- стандарт, стандартчиллын хөтөлбөрийн төсөлд санал өгөх.

Үүрэг:

- стандарт, техникийн зохицуулалтад тогтоосон шаардлагын дагуу бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах;
- стандартыг боловсруулах, бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулах, түүнтэй холбогдон гарах зардлыг санхүүжүүлэх;
- стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний асуудлаар холбогдох дүрэм, журам, баримт бичиг боловсруулах чиглэлээр ажилтнаа чадавхижуулах.

22.8 “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-д заасан барилгын материал, бүтээгдэхүүнийг импортлогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн тохирлын баталгаанд заавал хамруулна.

22.9 Гэрээ хэлэлцээрээр стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллага хүлээн зөвшөөрсөн тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг гэрчилгээтэй, хүчин төгөлдөр аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, импортоор оруулахад хяналт, тохирлын баталгаанд давтан хамруулахгүй.

22.10 Импортын барилгын материалын тохирлын баталгаажуулалтыг “Монгол улсад бүтээгдэхүүн ажил үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах нийтлэг журам”-ын 3 дугаар хавсралтад заасан схемийн төрлийн 8 дугаар схемийг баримтлан явуулна. /Схемийн үйл ажиллагааг Хавсралт-3 д үзүүлэв/

### **23 дугаар зүйл. Импорт, экспортын барилгын материал бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал**

23.1 Импорт, экспортын барилгын материал бүтээгдэхүүн нь физик-механик, эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлтээр материал, бүтээгдэхүүн бүрийн норматив техникийн баримт бичиг, холбогдох стандартын шаардлагыг хангасан байна.

23.2. Барилгын материал бүтээгдэхүүн нь нэр төрөлийн дагуу зориулалтын савлагаа, баглаа боодолтой байхаас гадна хаяглалтын мэдээлэл англи, орос, монгол хэлний аль нэгээр бичигдсэн байна.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ТӨРИЙН ҮҮРЭГ, ХЯНАЛТ**

### **24 дугаар зүйл. Энэхүү техникийн зохицуулалтын хэрэгжилтэд тавих төрийн хяналт**

24.1 Барилгын ажилд барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүнийг хэрэглэх явцад энэхүү техникийн зохицуулалтын шаардлагын хэрэгжилтэнд тавих хяналтыг Монгол улсын “Барилгын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Галын аюулгүй байдлын тухай”, “Цөмийн энергийн тухай”, “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулиудын дагуу төрийн хяналт гүйцэтгэх эрх бүхий байгууллага гүйцэтгэнэ.

24.2. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээний үе шат болон үйл ажиллагааны явцад эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн шалтгааныг тогтоох, таслан зогсоох, нийтэд шуурхай мэдээлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр зөвлөгөө өгөх, хяналт шалгалтыг төлөвлөж, хэрэгжүүлнэ.

24.3. “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 5 дугаар зүйлийн дагуу энэхүү техникийн зохицуулалтын шаардлагаар барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний тохирлыг хангах зарчмуудыг баримтална.

22.4 “Барилгын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Галын аюулгүй байдлын тухай”, “Цөмийн энергийн тухай”, “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хууль тогтоомжуудаар тогтоосон барилга, байгууламжийн чанар, аюулгүй байдлын биелэлтийг хангах ба зураг төсөл зохиох үндсэн өгөгдөл болох стандарт, норматив техникийн баримт бичгийн батлагдсан жагсаалтад орсон барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний үүрэг ба хэрэглээний тохирол, аюулгүйн шаардлагын үзүүлэлтүүдийг хангана.

24.5. Стандартын батлагдсан жагсаалтад орсон баримт бичгүүдийг хэрэглэх нь энэхүү техникийн зохицуулалтад тусгагдсан барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүний аюулгүй байдлын бүх шаардлагуудыг мөрдөх хангалттай нөхцөл болно.

24.6. Үндэсний болон гадаадын үйлдвэрлэгчийн үйлдвэрлэн нийлүүлж байгаа бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалтын шаардлагыг хангаагүйн хариуцлагыг үйлдвэрлэгчид, нийлүүлэгчид хүлээлгэнэ.

24.7. Хяналтын байгууллага нь барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын хяналтын байцаагчтай байна.

24.8. Барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, бүтээц, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд дараах байдлаар хяналт тавина:

24.8.1. Барилгын материалын нийлүүлэлтийн сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлс, барилга байгууламж, ажлын байр нь эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэхэд үзлэг шалгалт хийх;

24.8.2. Импортын болон дотоодод үйлдвэрлэсэн барилгын материалын эрдэс, органик түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүн холбогдох техникийн нөхцөл, эрүүл ахуй, бусад шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох, эрсдэлд суурилсан тандалтыг зохион байгуулах;

24.8.3. Зохистой дадлыг нэвтрүүлэх болон барилгын материалын эрдэс, органик түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох бүртгэлд хяналт тавих;

24.8.4. Барилгын материалын эрдэс органик түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргахдаа эрсдэлийн үнэлгээ, техникийн зөвлөмжид тулгуурлах;

24.8.5. Барилгын материалын эрдэс, органик түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт эрхлэгчийн бүртгэлийн нэгдсэн санг бүрдүүлж, зохих өөрчлөлт, хөдөлгөөн хийх талаар төрийн, төрийн бус байгууллага болон хэрэглэгчид шаардлагатай мэдээ, мэдээлэл өгөх;

24.9. “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 5<sup>4</sup>.3-т заасан эрсдэлд суурилсан хяналт шалгалтын давтамж тухайн үйлдвэрлэлийн онцлог, үйл ажиллагааны чиглэл, эрсдэлийн ангилалтай уялдсан байна.

24.10. Барилгын асуудал эрхэлсэн төрийн төв байгууллагын дэргэд барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаарх лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг удирдах, лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Барилгын материалын итгэмжлэгдсэн Улсын лавалгаа лаборатори ажиллана.

24.11. Барилгын материалын итгэмжлэгдсэн Улсын лавалгаа лаборатори дараах чиг үүрэгтэй байна:

24.11.1 Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тандалт судалгаа, үнэлгээ, шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох төрийн байгууллагад тухай бүрд хүргүүлэх;

24.11.2. Энэ техникийн зохицуулалтын 20.2-т заасны дагуу ирүүлсэн шинжилгээний дүнг нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлж, удирдах;

24.11.3 Барилгын материал, бүтээц ба бүтээгдэхүүнд тавих чанар, аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлж, стандарт, онцгой байдал, хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулах;

24.11.4 Эрсдэлийн үнэлгээг батлагдсан удирдамжийн дагуу эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн баг /цаашид “баг” гэх/-аар гүйцэтгүүлэх, багийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, үнэлгээний дүнг холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх;

24.11.5 Лабораторийн шинжилгээний шинэ аргачлал боловсруулах, лабораториудын ур чадварын сорилт зохион байгуулах, аргын баталгаажуулалт хийх;

24.11.6. Лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэргэжил дээшлүүлэх болон стандартын сургалт зохион байгуулах;

24.11.7. Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний аюулгүй байдлын талаарх онцгой байдлын болон эрүүл ахуйн арга хэмжээ, барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, үйлдвэрлэсэн материал бүтээц ба бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн төсөлд санал өгөх;

24.11.8 Барилгын материалын эрдэс, органик түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүний шинжилгээтэй холбогдсон маргааныг магадлан шинжлэх, шаардлагатай бол онцгой байдлын болон гамшгийн үед авсан дээжид шинжилгээ хийх.

24.11.9. Итгэмжлэгдсэн төрийн, орон нутгийн болон хувийн өмчит лабораториуд барилгын материалын түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын тандалт судалгаа, дээжийн шинжилгээ хийхэд оролцоно.

24.12. Барилгын материалын төв лабораторийн болон мэргэжлийн багийн ажиллах журмыг Барилгын асуудал эрхэлсэн төрийн байгууллага батална

## **25 дугаар зүйл. Барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, материал, бүтээц , бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаарх төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

25.1. Барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаар Барилгын болон хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

25.1.1. Барилгын материалын үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд зохистой дадлыг нэвтрүүлэх талаар сургалт зохион байгуулах;

25.1.2. Барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, бүтээц, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, барилгын материалын үйлдвэрлэлд ашиглах импортлох химийн бодисын аюулгүй байдалд тавих шаардлагыг тогтоох.

25.2. Барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах талаар Барилгын материалын үйлдвэрлэл, стандарт, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

25.2.1. Барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүний химийн бодисонд агуулагдах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг олон улсын стандартад нийцүүлэн тогтоох;

25.2.2. Химийн бодисын аюулгүй хэрэглээний түвшинг тогтоож, хэрэглэх нөхцөлийг тодорхойлох;

25.2.3. Барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүнээс шалтгаалсан мэргэжлийн өвчлөлийн үеийн тандалт судалгаа хийж, яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, үр дүнг нийтэд мэдээлэх.

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

### **26 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

26.1. Барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээц, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангах тухай техникийн зохицуулалтыг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч “Барилгын тухай”, “Зөрчлийн тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулиудын холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

26.2. Энэ техникийн зохицуулалтын дээрх заалтуудад тусгагдсан зөрчлүүдийг давтан гаргасан этгээдийн үйл ажиллагааг нь зогсоох буюу зөвшөөрлийг хүчингүй болгоно.

26.3. Энэ техникийн зохицуулалтын дээрхи заалтуудын дагуу захиргааны шийтгэл ногдуулсан нь буруутай этгээдийг учруулсан хохирлоо нөхөн төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

## **27 дугаар зүйл. Шилжилтийн журам**

27.1. Энэхүү техникийн зохицуулалтын үйлчлэл нь түүний хүчин төгөлдөр болж үйлчлэхээс өмнө үйлдвэрлэгдсэн болон энэхүү техникийн зохицуулалт үйлчилж эхлэх хүртэлх хугацаанд тохирлын үнэлгээнд ороогүй барилгын материал, бүтээц ба эдлэхүүнд хамаарна.

27.2. Энэхүү техникийн зохицуулалтыг үйлчилж эхлэхээс өмнө олгогдсон МУ-ын нутаг дэвсгэр дээр барилгын материал, бүтээц, эдлэхүүний хэрэглээний тохирлыг баталгаажуулсан тохирлын болон техникийн гэрчилгээнүүд нь тэдгээрийн үйлчлэлийн хугацааг дуусах хүртэл хүчинтэйд тооцогдоно

## **28 дугаар зүйл. Энэхүү техникийн зохицуулалтын үйлчлэх хугацаа**

28.1 Энэхүү техникийн зохицуулалт нь батлагдаж, түүнийг албан ёсоор хэвлэн нийтэлсэн өдрөөс хойш ..... сарын дараа хүчин төгөлдөр болж үйлчилнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР